

Төрийн албаны зөвлөлийн
2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн
80 дугаар тогтоолын б дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн
Боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Эрүүл мэндийн яам

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын
газар

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилаал, зэрэглэл:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын дарга

Эрхэлсэн түшмэл, ТЗ-13

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпын гудамж 2, Засгийн газрын VIII
дугаар байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичгийн
хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх,
тайлагнах, мэдээллээр хангах чиг үүргийн хүрээнд газрын үйл ажиллагааг удирдан зохион
байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг Төрийн нарийн бичгийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Эрүүл мэндийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавих;
2. Эрүүл мэндийн салбарт төрийн үйлчилгээний үйл явцад хяналт шалгалт, дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах;
3. Нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавих, тайлагнах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чиглэлээр гарсан хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах;	Нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангасан байна.	X, Ш
	2.Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй бусад бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах;	Нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангасан байна.	X, Ш
	3.Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах;	Тайлагнасан байна.	X, Ш
	4.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050"-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах;	Нэгдсэн удирдлага арга зүйгээр хангасан байна.	X, Ш
	5.Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах;	Нэгдсэн зохицуулалт хангагдана.	X, Ш
	6.Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөр/хөгжлийн зорилтот хөтөлбэрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах;	Үндэсний хөтөлбөр/хөгжлийн зорилтот хөтөлбэрийн хэрэгжилт үнэлгээ хийгдсэн байна.	X, Ш



ЗӨВШӨӨРӨВ
ГОДИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

	7. Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах;	Үнэлгээ хийхэд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангасан байна.	X, Ш
	8. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах;	Нэгдсэн удирдлагаар хангасан байна.	X, Ш
	9. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах;	Хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийгдсэн байна.	X, Ш
	10. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах, холбогдох тайлан мэдээлэл хүргүүлэхэд удирдлагаар хангах.	Мэдээллээр хангасан байна.	X, Ш
2 дугаар зорилтын хүрээнд	1. Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийхэд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах;	Хөрөнгө оруулалтын эрсдэлд сууринсан дотоод аудитын нэгдсэн зохицуулалт хангагдана.	X, Ш
	2. Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, буцалтгүй тусlamжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд дотоод аудит хийхэд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах;	Гадаадын зээл, тусlamжийн эрсдэлд сууринсан дотоод аудитын нэгдсэн зохицуулалт хангагдана.	X, Ш
	3. Баригдаж байгаа барилга, их засварын гүйцэтгэл, тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлт, ашиглалтын чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудад дотоод аудит хийж, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргахад нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах;	Хөрөнгө оруулалтын дотоод аудитын нэгдсэн зохицуулалт хангагдана.	X, Ш
	4. Эрүүл мэндийн байгууллагуудын санхүү, аж ахуйн үйл ажиллагааны эрсдлийг тодорхойлж, санхүүгийн хяналт шалгалтын үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргахад нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах;	Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлд сууринсан санхүүгийн хяналт шалгалтын нэгдсэн зохицуулалт хангагдана.	X, Ш



	5. Тусгай сан, төсвөөс олгосон санхүүгийн тусламж, дэмжлэг, зарцуулалтад хяналт шалгалт хийх, санал, зөвлөмж гаргахад нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах;	Хяналт шалгалтын нэгдсэн зохицуулалт хангагдана.	X, Ш
	6. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханггуулж, эрүүл мэндийн байгууллагуудын Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэн, зөв, бүрэн байршуулсанд хяналт, дотоод аудит хийхэд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах.	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хяналтын нэгдсэн зохицуулалт хангагдана.	X, Ш
3 дугаар зорилтын хүрээнд	1. Байгууллагын болон нэгжийн албан тушаалын чиг үүргийг гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэлтсийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйгээр хангах, батлах, хэрэгжилтийг ханггуулах;	Гүйцэтгэлийн үр дүн зохих журмын дагуу үнэлж, дүгнэгдсэн байна.	Г, Х, Ш
	2. Албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, үйл ажиллагааны уялдааг зохицуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;	Газрын албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдан ажилласан байна.	X, Ш
	3. Байгууллага, нэгжийн албан хаагчдын боловсруулсан албан бичиг, тушаалын шийдвэрийн төслийг хянах, архив, албан хэрэг хөтлөлтөд хяналт тавих;	Албан хэргийг стандартын дагуу хөтөлсөн байна.	X, Ш
	4. Албан хэрэг хөтлөлт, тайлан мэдээг цаг тухайд нь тайлгахаа ажлыг зохион байгуулах, хяналт тавих	Албан хэргийг стандартын дагуу хөтөлсөн байна.	X, Ш

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил	-эрүүл мэнд /091/; -эрх зүй /042/; -эдийн засаг /0311/; - нягтлан бодох бүртгэл /0411/; -менежмент ба удирдахуй /041301-041303/.
Мэргэшил	Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх.
Туршлага	Төрийн албанад 12-оос доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.



	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - нэгжийн үйл ажиллагаан дахь эрсдэлийн нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлийг илрүүлэх, шинжлэх, дүгнэх, эрсдэлийн арга хэмжээний хувилбарыг боловсруулах, хяналт тавих; - нэгжийн албан хаагчдад ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөх, чиглүүлэх; - албан хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих; - үл ойлголцол, саналыг зөрүүг эв зүйгээр зохицуулах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - мэдээлэлд тулгуурлан, бүтэц, чиг үүргийн болон салбарын системийн шинжилгээ хийх; - харьцуулсан судалгаа хийх, судалгааны үр дүнг үнэлэх, тайлбарлах; - шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх; - бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт зөвлөмж боловсруулах; - бусад.
Үр чадвар	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - хуульд нийцсэн оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - аливаа харилцааг хэрэгжүүлэх арга замыг хууль тогтоомж шийдвэрийн төсөлд тусгах, санал боловсруулах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний зэрэг, сөрөг үр дагаврын талаар тайлбарлах, зөвлөх; - бусад.
	Манлайлал	<ul style="list-style-type: none"> - байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх; - ёс зүйн хэм хэмжээг сахиж, хувийн зан төлөв, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэр дуурайлал үзүүлэх; - нэгжийн үйл ажиллагаанд шинэлэг санаа, үйлчилгээг нэвтрүүлэх, албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг манлайлах; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - харилцааны орчин үеийн арга хэлбэрийг ашиглах, мэдээллийг хүргэх; - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - комьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэй технологи ашиглах; - кирил болон үндэсний бичгээр албан бичиг боловсруулах чадвартай байх.



IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

- Эрүүл мэндийн сайд
- Дэд сайд
- Төрийн нарийн бичгийн дарга

Албан тушаалд шууд харьялан
удирдуулах албан тушаалын нэр, тоо:

- Ахлах шинжээч- 1
- Шинжээч- 3
- Мэргэжилтэн- 3

Нийт- 7

Бусад харилцах субъект:

- Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын Тамгын Газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам, агентлаг, харьяа байгууллагуудын холбогдох албан тушаалтан;
- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн зохицуулагч, ажилтан;
- Эрүүл мэндийн яамны харьяа агентлаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын албан тушаалтан;
- Мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтан, иргэн.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг
боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,
батлах зөвшөөрөл олгосон байгууллагын
шийдвэр:

Албан тушаал:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

.....*Д.Жамбайр*...../П.ЭРХЭМБАЯР/
2022 оны 03 дугаар сарын 14 -ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 22.0301

Дугаар: 080

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

Шийдвэрийн огноо:

Дугаар:

(тамга/тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Д.Жамбайр* /Ц.ЭРДЭМБИЛЭГ/

2022 оны 03 дугаар сарын 15 -ны өдөр

